



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/43

Мандалговь

“Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/”-ийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Гудамж, талбайн тохижилт, ногоон байгууламж /Дундговь/”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: Т.Төрбат (Иргэний төлөөлөл)
Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хэлтсийн дарга)

Нарийн бичиг: Б.Пэрэнлэймаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150090